

Дундговь аймгийн Засаг даргын Зам тээврийн хөгжлийн сайдтай 2022 онд хамтран ажиллах гэрээний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын тайлан


2022.12.13

Аймгийн Засаг даргын Зам тээврийн хөгжлийн сайдтай байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээг хийж, зөвлөн туслах арга хэмжээг зохион байгуулж удаашралтай байгаа заалтуудыг эрчимжүүлэх талаар үүрэг чиглэл өгч ажилласан.

НЭГ. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН


Аймгийн Засаг даргын Зам тээврийн хөгжлийн сайдтай байгуулсан хамтран ажиллах гэрээний 2022 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2-т заасан арга зүйгээр Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсээс ирүүлсэн тайланд үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Засаг дарга хамтран ажиллах гэрээгээр 29 үүргийг хүлээж жилийн эцсийн байдлаар 81.5 хувьтай хэрэгжүүлсэн байна. Үүнээс 3 арга хэмжээ аймагт хамааралгүй байна. Нийт 26 арга хэмжээ хэрэгжүүлэхээс 2 арга хэмжээ 100 хувь, 18 арга хэмжээ 90 хувь, 3 арга хэмжээ 70 хувь, 1 арга хэмжээ 50 хувь, 1 арга хэмжээ 30 хувь, 1 арга хэмжээ 0 хувьтай байна.



ХОЁР.ГЭРЭЭГЭЭР ХҮЛЭЭСЭН АРГА ХЭМЖЭЭНҮҮДЭЭС ДАРААХ АРГА ХЭМЖЭЭНҮҮД ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖСЭН ГЭЖ ҮЗЭВ.



2022 оны замын сангийн хөрөнгөөр аймгийн төвийн Номгоноос Өлзийт мандал хүртэлх автозам, явган хүний замын засвар, гэрэлтүүлэг, далан шуудууны тохижилтын ажилд 497 сая төгрөг батлан ажлыг “Буянцогт зам” ХХК хийж гүйцэтгэв.



Хулд сумаас 89-120км-ын хооронд зам их хэмжээний эвдрэлтэй байгаа тул шороон зам их үүссэн тул зорчих хөдөлгөөнийг замын 2 талаар шороон замыг хуссан.



Аймгийн төвийн 2,8км хатуу хучилттай авто зам, Эрдэнэдалай сумын 2км авто зам, Онги голын төмөр бетон гүүр гэсэн 3 төсөл арга хэмжээний ажил он дамжин "Аймгийн төвийн 2,8 км хатуу хучилттай авто зам", "Онги голын төмөр бетон гүүр"-ний ажил хүлээн авсан. Эрдэнэдалай сумын 2 км авто замын барилгын ажлыг "Өлзий хутгийн наран" ХХК 1,5 тэрбум төгрөгийн ажил 50 хувьтай, гэрэлтүүлгийн ажлыг "Анар зоне" ХХК-тай 217 сая төгрөгөөр гэрээ байгуулан ажлын гүйцэтгэл 100 хувьтай



2022 оны замын сангийн хөрөнгөнд аймгийн төвийн авто замын засвар, нөхөөс, тэмдэг тэмдэглэгээний ажилд 290,6 сая төгрөг, зам засварын тоног төхөөрөмжид нийлүүлэх ажилд 59,0 сая төгрөгийн 2 ажил баталсан. Аймгийн төвийн авто замын засвар, хурд сааруулагч угсрах ажлыг 7-р сард хүлээн авсан. Хот тохижуулах газар нэмж нөхөөс гарсан ажлыг аж ахуйн аргаар засварласан.

"Гэрлээрээ анхааруулъя", "Уусан бол бүү жолоод" нөлөөллийн, "Аажуу явбал аяндаа хүрнэ дээ" зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулан зам тээврийн ослын хор уршиг, түүнээс үүдэн гарах хор хохирлын талаар таниулах, иргэдэд замын хөдөлгөөнд аюулгүй, зөв оролцох мэдлэг мэдээлэл олгож, зөв дадалд хэвшүүлэх зорилгоор "Орон нутгийн замын цагдаа", "Дундговь Цагдаагийн газар" facebook хуудсанд 9 удаа байршуулж, орон нутгийн замд зорчиж байгаа иргэд, жолооч нарт анхааруулга, сэрэмжлүүлэг тогтмол өгч ажиллалаа. Зам тээврийн гэмт хэрэг, ослын нөхцөл байдал, түүнээс урьдчилан сэргийлэх ажлын чиглэлээр "Согтуугаар тээврийн хэрэгсэл бүү жолоод", "Та бага насны хүүхдийг зориулалтын суудалд суулгаж аюулгүй зорчих", "Хамгаалах бүсээ бүслэх гурван секунд таны ирээдүйн амьдралын баталгаа", "Жолооны ард утсаар бүү оролд бүү ярь", "Таны хурд хэтрүүлсэн хором мөч бүхэн хэн нэгний амьдралыг орвонгоор нь өөрчлөхөд бэлэн байдаг" гэх зэрэг 5 төрлийн 150 ширхэг санамж, сэрэмжлүүлэг, зөвлөмж замын хөдөлгөөнд оролцож буй жолооч нарт тарааж ажилласан. Энэ төрлийн гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр 2 удаагийн подкаст, 2 төрлийн видео зохиомж, 13 төрлийн зурагт хуудас хийж байгууллагын цахим хуудас болон олон нийтийн сүлжээнд байршуулан нийт 1,538,000 хэрэглэгчийн хандалт хийгдсэн байна. Хүүхдийг зам тээврийн хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөнд оролцох зөв дадалд сургах,

аюулгүй байдлаа хэрхэн хангах талаар хууль, эрх зүйн мэдлэг олгох, тэдний эцэг, эх, асран хамгаалагч нарын үүрэг хариуцлагыг сайжруулах, сургуулийн багш, нийгмийн ажилтнуудын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Ногоон гэрэл - Цагаан шугам 2022” тэмцээнийг аймгийн Цагдаагийн газар, ГХУСАЗСЗ-тэй хамтран амжилттай зохион байгуулсан.

ГУРАВ. ДУТАГДАЛТАЙ ХЭРЭГЖСЭН АРГА ХЭМЖЭЭ:

Авто замын дагуух үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагуудын ажилчдад эмнэлгийн анхны тусламж үзүүлэх болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх мэдлэг чадвар олгох, тогтолцоог бүрдүүлэх талаар тодорхой үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.2-д заасны дагуу дэд бүтэц, нийтийн зориулалттай авто зам, замын байгууламжийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байлгах шат дараалсан арга хэмжээний төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавих арга хэмжээний хүрээнд Номгоноос Өлзийт мандал хүртэлх автозамд 380м хөгжлийн бэрхшээлтэй хүний хөтөч замыг хийж гүйцэтгэв. Төлөвлөгөө хөтөлбөр боловсруулагдаагүй.

ДӨРӨВ: ГЭРЭЭНИЙ ЗӨВЛӨМЖ, ДҮГНЭЛТ


Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээний Зам тээврийн хөгжлийн салбарын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг 81.5 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлж үнэлгээний саналыг хүргүүлж байна.

Гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 36 хавсралтын дагуу оны эхэнд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн төлөвлөлтийн шаардлагыг ханган томъёолж, шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлон, суурь түвшин, хүрэх түвшнийг бодитой тооцон төлөвлөж батлуулах, хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж байх шаардлагатай байна.

Баталгаажуулсан:

Аймгийн Засаг дарга  Ц.Мөнхбат

Хянасан:

Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч  Д.Даариймаа

Тайлан бичсэн:

Хяналт шинжилгээ, үнэлгээний

хэлтсийн ахлах мэргэжилтэн 

Э.Одончимэг

